

## ХОЁР ЁСНЫ СУРГААЛД ТӨР ЁСНЫ АСУУДЛЫГ ХӨНДСӨН НЬ

Ц.ГАНБОЛД

Профессор, МУИС. Улс төр судлалын тэнхим

Л.ИДЭР

Улс төр судлалын тэнхимийн докторант

**Түлхүүр үг:** Төр, хоёр ёсны сургаал, Цагаан түүх

**Хураангуй:** Шашин, төр хоёр ёсыг хослуулан явуулах бодлогын гол агуулга бол шашны засаг, хааны засаг хоёрыг төв тэгш явуулах хэмээсэн утгатай бөлгөө. Үүнийг сурвалжид “Дөрвөн их төр” гэдэг. Тухайлбал, “Номын төр тарни, судар хоёр, ертөнцийн төр энх, хялбар хоёр” болно. “Номын засаг үгүй болбоос амьтад тамд унаж, хааны засаг үгүй болбоос улс аймаг эвдрэх болно” хэмээдэг. Тиймээс хоёр ёсны улс төрийн асуудлыг тодруулан авч үзэх нь чухал юм.

\*\*\*

Хоёр ёсны асуудлын талаар нилээдгүй мэдээг агуулсан сурвалж бол цагаан түүх зохиол юм. <<Арван буянт номын цагаан түүх>> гэдэг энэ номыг голчлон <<Цагаан түүх>> хэмээн нэрлэж заншжээ. Цагаан түүх ном нь хэд хэдэн хувилбартай. Энэ нь XIII зууны түүхийн тулгар бичгийн нэг мөн. Тус ном бол Хубилай цэцэн хаан зохиосон хэмээн Ордосын Хутагтай цэцэн хун тайж мэдээлжээ. Мөн эрдэнийн товчид иш татан бичсэн оршил өчил ч бас бий.

Зан заншил хэв ёсыг хэвшүүлэх, ажил үйлсийг зааж зааварласан нь их сонин бөгөөд нүүдэлчин ард түмний амьдралд өнөө хэр ч чухал ач холбогдолтой зүйл байгаа нь монгол улсын төрийн үйл ажиллагаа явуулахад ихээхэн хувь хандив үзүүлж болох юм. Цагаан түүхийн 49-р хуудсанд 1-8 зүйлд заахдаа уул даваа, их голын дэргэд манаа харуул тавих, далай, гол мөрөнд хяналт тогтоох, 4-5 дугаар зүйл гэхэд хулгайг сэргийлэхийн тулд нохойг тэжээ, цагийн тулд тахна тэжээ, гэх мэтээр тодорхой заасан зүйл арвин байна. Тэр ч төдийгүй улсын тэргүүний үйлийг зааж, хил хязгаарыг батлан хамгаалах талаар дурдсан буй.

Монголчуудын зан заншил, ёс зүйн тухай өгүүлэхэд зан үйлийн асуудалд анхаарлаа хандуулах нь чухал юм. Зан үйл нь нилээд төлөвшин тогтож ирэхдээ улс гүрэн ёс дэг, зан заншил, бүхнийг дагаж мөрдөх хэв ёсны шинжтэй болдог ажээ. Ийм учраас монголын төрт ёс, ёс заншлын уламжлалаас суралцах шинэ нөхцөл байдалд тохируулан хэрэглэх зүйл олон буй юм. Эртний монгол газар нутаг дээр төр улс үүсэн тогтсон цагаас эхлэн төр, засаглалын хэм хэмжээ бий болон төлөвшиж иржээ. Монгол улсад төр зан заншил уламжлалтай салшгүй холбоотой хөгжиж иржээ. Төрд зан заншил уламжлал ихээхэн нөлөөтэй байсан нь амьдрал ахуйтай ойр, хүний оюун ухаанд шингээж өгч байснаараа онцлог юм. Ийнхүү ард түмний зан заншил, хэв ёсыг дээдэлж чадсанаар Монгол улсын төр хүчин чадалтай, амьдралд хэрэгжиж биелэлээ олж байжээ. Монголын төрийн уламжлал нь дараа дараагийн үедээ уламжлал болон төр засаглалын эх сурвалж нь болж хөгжиж ирсэн. Монголын төрийн уламжлал, зан заншлын хэм хэмжээ нь онцлог төдийгүй нийгмийн харилцааг зохицуулахад зонхилох нөлөө үзүүлж он цагийн явцад улам төгөлдөржин боловсронгуй болсоор ирсэн байна.

Эртний Монгол нутагт амьдарч байсан нүүдэлчдийн төр, улс байгуулах гэсэн хүсэл, сэдэл, үйл ажиллагаа нь тэдний өөрсдийнх нь дотоод, гадаад хөгжлийн өвөрмөц онцлог бүхий шууд үр дагавар байв. Монгол газар тархай, бутархай байсан олон овог аймгийг нэгтгэн нягтруулж, төр улс байгуулсан нь юуны өмнө тэдгээр овог, аймгийн нэр хүнд бүхий удирдагчийн үйл ажиллагааны шууд үр дагавар, нөгөө талаар монгол төрийн үндэс суурийг бүрэлдүүлэн төлөвшүүлэхийн эхлэл, үүсгэл, түүнчлэн хэв ёс зан заншлын хэм хэмжээг хойш хойшдоо өвлөн уламжлуулах түүхэн бодитой үйл явц байжээ. Монгол нутагт үлдэж хоцорсон хад чулуунд сийлсэн үйсэнд бичсэн хаадын зарлиг захиас, мөн пайз, тамга, гэрэгэ зэрэг төрийн үйл явцтай холбоотой эх баримт сэлтүүд нь Монгол оронд төрт ёс хөгжиж хойч үедээ уламжилж ирсний баталгаа ач холбогдолтой эх сурвалж мөн. Монголчуудын төр ёсоо хүндлэн дээдлэх, хуулиа чанд сахин биелүүлэх нь хэдийгээр нэгдсэн төр түүнээс өмнөх үеийн төрийн хэмжээний хүчин чадлын нэгэн илрэл боловч Монголчуудын нэн эртнээс эхлэн <<Хөх тэнгэр>>-ийг шүтэн биширч хааныг тэнгэртэй адилтгаж түүний гаргасан зарлигийг бүхнээс хүчтэй хэмээн үзэж байсан нь Монголчуудын төрөө хүндлэх, хуулиа дээдлэх үзэл бодол төлөвшихөд чухал нөлөө болсон байна. Шашны зан үйлийн ийм байдлыг шилжүүлэн авч төрийн хуульд тусгаж хуульчилж байсан нь Монголчуудын төрт ёсны үйл ажиллагааны нэгэн өвөрмөц онцлог байв. Монголчуудын төрт ёсны үзэл санаа, түүнчлэн хууль цааз, цэрэг, дипломатын ёс, заншил, шашны зан үйлийн хэм хэмжээнүүд Монголын нийгмийн харилцааг зохицуулахад чухал хүчин болж байсан бөгөөд улмаар эдгээр нь Монголчуудын төрт ёсны сэтгэлгээг хөгжүүлэхэд чухал нөлөө үзүүлжээ гэсэн дүгнэлтэнд хүрч байна.

Шашин, төр хоёр ёсыг хослуулан явуулах бодлогын гол агуулга бол шашны засаг, хааны засаг хоёрыг төв тэгш явуулах хэмээсэн утгатай болгоо. Үүнийг сурвалжид “Дөрвөн их төр” гэдэг. Тухайлбал, “Номын төр тарни, судар хоёр, ертөнцийн төр энх, хялбар хоёр” болно. “Номын засаг үгүй болбоос амьтад тамд унаж, хааны засаг үгүй болбоос улс аймаг эвдрэх болно” хэмээдэг. Ингээд Хубилай хаан бурханы шашныг төрийн шашин болгож, Төвдийн Пагва ламыг “Хааны багш”, “Улсын багш” өргөмжилж, бүх улсын шашны үйл хэргийг эрхлүүлсэн бөгөөд “Ном айлдах үйлс хийгээд хүн цөөхөн цагт Пагва лам дээр суух, хаад хийгээд ноёд түшмэд тэргүүтэн олон түшмэд хурсан цагт хаан дээр суух” гэх мэтчилэн хаантай тэгш байр суурьтай байхаар зохицуулжээ.

Хоёр ёсны үзэл баримтлалыг тодорхойлон бичсэн нь Юань гүрний үед зохиогдсон манай түүхийн үнэт сурвалж болох “Арван буянт номын цагаан түүх” юм. Түүний оршил хэсэгт: “Үнэн хоёр ёсны тэгшид эндүүрэлгүй явуулахын товчоон Арван буянт номын цагаан түүх” гэж тодорхойлон бичсэн байдаг нь чухамхүү тус шастирын үндсэн үзэл санаа бол хоёр ёсны үзэл баримтлал гэдгийг нотолж байна. Ингээд хоёр ёс гэдгийг: “Түүгээр эн тэргүүн хоёр ёсыг аль буй хэмээвээс, номын төр тарни, судар хоёр хийгээд ертөнцийн төр энх, гилбэр хоёр ёсноос...” гэсэн нь энэхүү хоёр ёсон хэмээгч нь шашин төр хоёр буюу, хүмүүний энэ ертөнцийн хэрэг, зол жаргал-энх амгаланг эрхлэгч ертөнцийн төр буюу хааны төр хийгээд хүмүүний сэтгэл оюуны эсрэг, хойт насны зол жаргалыг номын төр буюу шашны төр хэмээгч хоёр зүйлийн төр байх ажгуу. Үүнд, бурханы шашны сургаалаар хүмүүнийг энэ ертөнцийн зовлонгоос гэтэлгэгч их хөлгөний буюу судрын зам мөр байх тул шашны төр нь тэр бүхнийг хамарсан судрын ба тарнийн хэмээх хоёр засагт, нөгөө Ертөнцийн төр нь ард олныг элбэрэн нигүүлсэх, энэрэн тэтгэхүйн үйлийг эрхлэгч энх төр хийгээд төрийн албадлага хүчирхийллийн үүргийг хэрэгжүүлэгч гилбэр буюу дайчин төр хэмээх хоёр хэсэгт хуваана. Эдгээр нь бүхэлдээ хоёр ёсны дөрвөн их төр хэмээн нэрлэгдэх хийгээд энх төрийг төрийн эзэн хаан голлон эрхэлж, харин төрийн захиран дарангуйлах чиг үүргийг түүний түшмэд голчилж хэрэгжүүлэх учиртай. Тийнхүү иргэн урганыг “Гар газар, хөл хөсөр” талбиулах, илбэн тохинуулах төрийн чиг үүргийг төрийн эзэн хаан дагнан эрхэлж, харин дайчин төр буюу захиран дарангуйлах хүчирхийллийн чиг үүргийг эзэн хааны нэрийн өмнөөс түүний түшмэл голчлон эрхэлж хэрэгжүүлэх учиртай гэнэ. Үүнд ч, Монголын (бурхны шашны) төр ёсны сэтгэлгээний нэгэн гол баримтлал оршино хэмээдэг. Хураан өгүүлбээс, Юань улсын төрийн байгууллыг бүрдүүлэхдээ нэгэн талаас хаан тэргүүлэн түшмэдийн эрхлэн хэрэгжүүлэгч хааны төр буюу иргэний төр, нөгөө талаас улсын багш тэргүүлэн лам хуврагуудын эрхлэн хэрэгжүүлэгч шашны төр буюу сүм хийдийн байгууллыг зэрэгцүүлэн босгож, өөр хооронд нь шүтэлцүүлж тавьсан хэрэг ажгуу.

Чухам ингэж иргэний (харын) болон сүм хийдийн байгуулал зэрэгцэн оршиж, өөр өөрийн үйлийг эрхэлж, бас бие биеэ нөхөж чадсан цагт сая “үнэн номын засаг хивийн зангиа мэт алдаршгүй хүнд, хааны засаг алтан буулга мэт эвдэршгүй” болох учиртай ажгуу. Энэхүү хоёр ёсны аль аль нь дутаж болшгүй гэдгийг “Цагаан түүхэнд”: “Ер хоёр ёсоор эс явбаас буян хилэнц хоёр, хар цагаан хоёр, хүнд хөнгөн хоёр, үнэн худал хоёр, сайн муу хоёр, жаргал зовлон хоёр, эд бүхний ялгалыг үл мэдэхийн тул”, “Тэр мэт номын засаг үгүй л бөгөөс амьтан там дор унаюу, хааны засаг үгүй бөгөөс улс аймаг эвдрэх больюу., лам багшийг дагаж шүтвээс бодисадын мөрийг олыюу, буянт хаан дор шүтвээс ертөнцийн улс сайтар амарлиюу” гэж үндэслэж дүгнэсэн байна. Тийнхүү бурхны шашны гүн ухааны хамгийн язгуур онолын нэг-үйлийн үрийн шүтэн барилдлагын хуульд үндэслэн хүмүүний энэ, хойд хоёр насны зол жаргал, сайн сайхныг хангахын тулд номын ба ертөнцийн хэмээх хоёр засаг зайлшгүй гэж үндэслэсэн ажгуу. Учир шалтгаан тиймийн тул, “Түүгээр үнэн номын төр дотоод зүрхэн, хүнд хааны төр гадны хар нүдэн мэт буюу” гэж тэдгээрийн аль аль нь орхигдон дутагдаж болшгүй гэдгийг зүйрлэн илэрхийлнэ.

“Цагаан түүхэнд” дурдсан хоёр ёсны сургаал үгэнд

“Санваар үгүй тойд үнэн номыг салхинд хийсгэюү

Төр үл мэдэх ноёдын засаг уулнаас хүнд” гэсэн нь сахил санвааргүй тойд шашин номыг үгүй хийж, төрийн ёс үл мэдэх ноёд уулнаас хүнд суртлаар ардыг зовооно гэсэн агуулгатай юм.

Монгол иргэншлийн үүсэл хөгжлийн аль ч үед төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдлэх зарчим бодитойгоор хэрэгжиж ирсэн нь орчин цагийн Монгол иргэншлийн өөрчлөлт хөгжилтөд зайлшгүй уламжлагдах учиртай үндэсний үнэлэмж мөн. Хубилай (1215-1294 он) сэцэн хааны үеийн төр, шашны хоёр ёсыг тэгш хослон явуулах тухай хууль цааз цоморлогийн эмхэтгэл болсон “Арван буянт номын цагаан түүх” хэмээх дурсгал бичигт “номын засаг үгүй бөгөөс амьтнууд тамд унаж, хааны засаг үгүй бөгөөс улс аймаг эвдрэх больюу” хэмээн тэмдэглэгдэж номын ёс, ертөнцийн ёсыг хослон барих уламжлал тогтсон билээ. Монгол иргэншлийн төр ёсны түүхэн дэх эл уламжлал түүхийн өөр өөр цаг үед янз бүрийн өнгө аястайгаар өвлөгдөж өнөө үед ирэхдээ оюуны соёлын уламжлалд гүнзгий шингэн идээшсэн юм. “Цагаан түүх”-ээс эхтэй төр, шашин хоёрыг тэгш хослон явуулах энэхүү үзэл санаа бол төрөө төвхнүүлэх төрийн албыг олон түмний итгэл бишрэлээр дамжуулан зүй зохистой хэрэгжүүлэх, төр ба шашны харилцааг үндэсний иргэншлийн онцлогт нийцүүлэн үр нөлөөтэй зохион байгуулах талаар хүн төрөлхтөний төр, иргэншлийн сан хөмрөгт монголчуудын оруулсан гайхамшигт хувь нэмэр мөн. Төрийн эрх мэдлийг тэнцвэржүүлэн хуваарилах тухай Ш.Н.Монтескье-ийн онолоос ач холбогдлын хувьд дутахааргүй тийм үзэл онолыг бидний өвөг дээдэс “Цагаан түүх”-дээ бүтээж өгсөн юм шиг санагддаг.<sup>1</sup>

<sup>1</sup> Чулуунбаатар Г “Монгол иргэншил ба шашин шүтлэг: уламжлал шинэчлэл УБ.,1998 он, 36 дахь тал”

Судлаачдын бүтээлээс үзэхэд төр, шашны хоёр ёсыг тэгш явуулах тухай “Цагаан түүх”-ийн үзэл санаа бол төрийн “төмөр нударгаар” шууд захиран зарцуулж болдоггүй хүний дотоод сэтгэлийн гүнзгий итгэл үнэмшлийн үнэлэмж болдог нийгмийн сэтгэл зүйн тийм үзэгдэл, харилцааг шашин номын механизмаар зохицуулж, тэр нь төр түмний хэрэгт тус болж байхаар зохион байгуулагдсан Монгол иргэншлийн өвөрмөц содон шинжийг илтгэж байна уу даа? гэсэн санаа төрснийг энд онцлон тэмдэглэе.<sup>2</sup> Тийнхүү өрнө дахинд бүх дундад зуун, сэргэн мандалтын үеийг туулж, шашны инквизицийг үзэн өнгөрүүлж байж хүрч ирсэн хүн төрөлхтөний сэтгэлгээ, иргэншлийн нэг томоохон ололт болсон сүм хийдийг төрөөс тусгаарлах шашны бус, иргэншилт төрийн үзэл санаа “Цагаан түүхнээ” өвөрмөц хэлбэрээр тавигдаж байгаа нь сонирхолтой байна. Гэхийн хамтаар Юань улсад шашны ба ертөнцийн хэмээх яг адил тэнцүү, эрх тэгш хоёр байгуулал, хоёр төр байгаа юм бас бишээ. Тухайлаад, зарим судлаачдын дүгнэсэнчлэн төрийн эзэн хаан, номын эзэн хаан лам хоёр яг адил тэнцүү эрхтэй байхаар тогтоосон нь хараахан бусаа. Харин ч “Цагаан түүхэнд” дээрх хоёр ёсны дөрвөн төрийг нийтэд нь басхүү хаан хүмүүний харъяат дөрвөн их төр гэж бүхэлдээ улс орны дээд эрхэт эзэн нь эцсийн дүндээ төрийн эзэн хаан л мөн гэдгийг онцолно.

Энэ талаархи өөр нэгэн сонирхолтой баримтыг Зава Дамдин гавж Монголын орноо дээдийн ном дэлгэрсний түүх “Алтан дэвтэр” хэмээх зохиолдоо тэмдэглэсэн буй. Тэрээр Үүнд, Хубилай бээр Пагва лам лугаа багш шавийн барилдлага тогтоон номын абшиг хүртэхийн цагт шавийн ёсоор “тангараг дор багш бээр дээр суух ба шавь бээр дорд суудал барих бөгөөд дээд гурван эрдэнийг аврал дор бариад, бодь сэтгэл лүгээ үл хагацах хийгээд лам багшийн зарлигаас үл давах тэргүүтэн тарнийн тангараг” авах хэрэгтэй болсон боловч “Ламын зарлиг бүхнийг дагах хэрэгтэй болох бөгөөс би бээр их хаан мөний тул түүнийг үл чадамуй хэмээн зарлиг болгосноор” зөвшилцөн тохиролцсон нь “Ертөнцийн үйлс дор хаан эрхин бөгөөд дээд суудал барьж, ном айлдахын үесэд зарлигчлан бүтээгээд түүнээс бус их, бага бусад үйл дор лам зарлиг болохыг бүү зохио” гэж шийдсэн хэмээмүй.

Тийнхүү номын эзэн ламын үйлсийг гагц шашин-номын үйлсээр нь чанд хязгаарлаж, бусад их бага аливаа хэрэгт хаан (буюу төр) ямагт эрхэн байхаар тогтоосон ажгуу. Ерөөс, төр-сүм хийдийн харилцаа ямар байх нь тухайн цагийн түүхэн нөхцөл, хүчний харилцаа хэрхэн бүрэлдэж тогтсоноос хамаардаг зүй тогтол энд ч мөн л илэрч байгаа хэрэг. Дундад зууны нөхцөлд хаан төр өөдлөн дэвжиж яваа цагт шашин-сүм хийд нь түүнийгээ дагаж, түүний туслагч холбоотон нь болдог, харин хаан төр суларч доройтохын цаг үесэд шашин-сүм хийд нь эз дийлэн давамгайлж, хаан төрийн өмөг түшиг, ивээн тэтгэгчийн үүргийг гүйцэтгэдэг. Дундад эрин үеийн өрнө дахинд ч ийм л байсан. Монголын хувьд ч тийм л байлаа.<sup>3</sup>

Чингэхүйеэ, Юань улсын үеэс, ялангуяа Хубилай хааны цагт Монголын төр чухам идэрмэг хүчирхэгийнхээ оргилд тулж явсан цаг үед тохиох тул тэрбээр бурханы шашныг хүчирхэг ивээн тэтгэгчээ бус, харин чухаг нэгэн холбоотон, туслагчаа л болгосон хэрэг ажгуу. Тэгээд ч, бурханы шашныг залж буй Төвд орон нь өөрөө улс төрийн хувьдаа Монголын эзэнт гүрнээс хараат байдалд асан ажгуу. Цаг үе, түүхэн нөхцөл байдлын ийм өвөрмөц хослол нь төр, сүм хийдийн харилцааны дээрх шийдлийг нөхцөлдүүлсэн түүхэн бодит үндэслэл мөн гэлтэй.

Төрийн байгууллыг эмхлэн бүрдүүлэх лүгээ уялдуулан төрийн эзэн хааны эрхлэх гурван их үйл, дөрвөн их төр, зургаан их үлгэр, долоон их бин, есөн их билгийг тус тус тодорхойлсон нь төрт ёсны сэтгэлгээний сонирхолтой баримт болж байна.

Үүнд, эн тэргүүнээ хаан хүмүүний харъяат гурван их үйл хэмээхүй нь: хоёр ертөнц дор аврагч амгалангийн дээд үйл, иргэн урганыг засахуйг оногч жаргалангийн дээд үйл, улсыг сахихуй явдлыг ухагч үйлсийн дээд үйл, эл гурав хэмээнэ. Өөр үгээр хэлэхүл, төрийн эзэн хаан, нэгэн талаас улс орондообурханы шашныг тэтгэн дэлгэрүүлснээр иргэн олныг энэ, хойд ертөнтөд зовлонгоос гэтэлгэн амарлуулах, нөгөө талаас, цэргийн хүч эрдмийг боловсруулан улсын сүр хүчийг бадруулах хийгээд дотооддоо ард иргэнийг асран нийгүүлсэхүйг гол болгох, энэ бүхнийгээ хүчээр хотлыг захирсан чакравардын их хаан болж чадах хэмээсэн утга ажгуу. Энэ гурав нь сац хаан хүмүүний эрхэмлэх гурван үйл мөн хийгээд түүн лүгээ шүтэлцэн төрийн эзэн хааны барих дөрвөн их төр гарч ирэх ажгуу. Эл дөрвөн төр хэмээх нь, нэгдүгээрт, их хөлгөний ёсон амгалангийн төр, хоёрдугаарт, хааны барих энх төр, гутгаар, нууц хөлгөний ёсон жига төр, дөтгөөр, түшмэдийн барих дайчин төр, хэмээх дөрвөн төр мөн гэнэ. Чингэхүйеэ, хаан хүмүүний харъяат дөрвөн төр гэж эл дөрвөн төрийг бүхэлд нь төрийн эзэн хаан нэгтгэн эрхлэх авч чухамхүү энх төр буюу ард иргэнийг асран нийгүүлсэхүй, элбэн тохинуулахуйн үйлсийг төрийн эзэн хаан дагнан хэрэгжүүлэх учиртай ажгуу. Энэ нь дээр товч дурдсан хаан хүмүүний гурван их үйл дэх ард иргэнийг засан тохинуулахуйд тэдний энх жаргаланг эрхэм болгох хэмээсэн жаргалангийн дээд үйл лүгээ авцалдан барилдах учиртай ажгуу.

Ерөөс энд дурдагдан буй их хөлгөний амгалангийн төр хэмээх нь үүний өмнө авч үзсэн хоёр ёсны дөрвөн төр хэмээхийн нэгэн-судрын ёсныг, нууц хөлгөний жига төр хэмээх нь тарнийн ёсыг, энх төр дайчин төр хоёр нь энх, гилбэр хоёр төрийг тус тус илэрхийлэх буюу товчоор хэлэхэд, хаан хүмүүний бурханы шашныг удирдлага

<sup>2</sup> Мөн гэнд

<sup>3</sup> Төр, сүм хийдийн харилцаа: Орчин үе УБ., 1998 он, 96 дахь тал

болгож, хоёр ёсны зарчмыг тууштай тогтоон хэрэгжүүлэх учиртай гэдгийг л энэхүү дөрвөн их төр хэмээх ойлголтоор илэрхийлсэн хэрэг болно. Учир шалтгаан тиймийн тул агуулга, багтаамжийнхаа үүднээс, энэхүү дөрвөн төр хэмээх ойлголт нь "Цагаан түүхийн" үндсэн үзэл санаа болсон хоёр ёсон хэмээх ойлголт лугаа эн сацуу буюу; тийм ч учраас тус сурвалж бичгийг өөрөөр басхүү "Дөрвөн төрийн арван буянт номын Цагаан түүх" гэж нэрлэдгийн учир тэр болно.

Цаашилбаас, хаан хүмүүний зургаан их үлгэр хэмээх нь даруй төрийг засахдаа удирдлага болговоос зохих эрхэм зүйлс, үлгэр дуурналал мөн болно. Үүнд, ертөнцийг байгуулсан ухааны үлгэр буюу монголын төр, улмаар эртний олноо өргөгдсөн хаанаас үүдэл бүхий төрийн уламжлалт ёсон, хоёрдугаарт, бурханы санг байгуулсан вивангирдийн үлгэр буюу бурханы шашны номлол сургаалийн сан, гуравдугаарт, засгийг явуулахуйяа байгуулсан ёслохуйн үлгэр буюу "Төмбөгөр төрийн ёмбогор ёсон", дөрөвдүгээрт, зоригийг байгуулсан хэмжээний үлгэр буюу төрийн эзэн хааны зориг хүслийн илэрхийлэл болсон хууль цааз, дүрэм горимын цогц, тавдугаарт, цэргийг байгуулсан тэтгүүлэхүйн үлгэр буюу улсыг сахин хамгаалах цэргийн эрдэм ухаан, эцэст нь, хүү санг байгуулсан арвитгахуйн үлгэр буюу эдийн засгийн бодлого-улсын сан хөмрөгийг арвилан хэмнэхүйн ухаан; эдгээр болно.

Чингэхүйеэ, хаан хүмүүний зургаан их бин хэмээх нь мөн л хоёр ёсон буюу, нэгэн талаас, бурханы шашны сургаал, нөгөө талаас, төрийн уламжлал, ёс журам, хэм хэмжээг удирдлага болгон бурханы шашныг түгээн дэлгэрүүлэх хийгээд улсыг батлан сахих, эдийн засгийг арвижуулан дэлгэрүүлэхийг эрхэм болгох гэсэн утга болно.<sup>4</sup>

Энэхүү долоон эрдэм нь:

- Өнгөрснийг хөөж мэдэх гүн ухааны бин;
- Ирээдүйг угтаж онох дээд зөнчийн бин;
- Битүүг таньж онох үлэмж мэргэний бин буюу зөн билгийн мэдлэг болон;
- Эдүтээ ахуйг төгс онохуйн магад мэдэхүйн бин буюу өнөө цагийг төгс танин мэдэхүйн, эн тэргүүнээ улс төр, нийгмийн мэдлэг ухаан;
- Бусдын санааг урьтаж мэдэхүйн бин буюу гайхамшигт сэцний мэдлэг;
- Аян авын үйлийг мэдэх чадал баатарын бин;
- Таван ухааныг төгсгөсөн гэгээн билгийн бин буюу бурханы шашны их таван ухаан, эдгээр болно.

Эцэст нь, харьяа ихт хар туг, хашгираа ихт улаан бүрээ, хүч ихт алтан хор /сум/, цог ихт шар шүхэр, зангараг ихт алмас илд, чийрэг сайн алтан эмээл, эгэл ихт хүнд бүс, өндөр далбаат исэр болон түшээ сайт өрлөгүүд хэмээх хаан хүний есөн их билгийг тодорхойлсон буй. Эд бол төрийн эзэн хааны хотлыг захирсан сүр хүч, эрх мэдлийн бэлгэ тэмдэг мөн болно.

**Abstract:** Main concept of the theocratic policy is to keep balance between state religion and monarchy. Theocracy in Mongolia cited as "DurvunlkhTur", "4 big theocracy", ( Dual system of government ) in historical sources. According to these sources, sutra and mantra belong to a state religion while peace and easiness belong to a government. If there is no state religion, people are sent to hell. If there is no monarchy, state are turned to separation. So it is very important that studying theocracy.

### НОМ ЗҮЙ:

1. "Арван буянт номын цагаан түүх". "Монголын түүхэн сурвалж бичгийн 2-р боть", УБ., 2006 он
2. Бира Ш."Монголын түүх, соёл, түүх бичлэгийн судалгаа", УБ., 2001 он
3. Бира Ш, Түүвэр зохиол, "Монголд нэгдсэн төр байгуулагдаж феодализм бүрэлдэн тогтсон нь", УБ.,1960 он
4. Ишжамц.Н "Монголд нэгдсэн төр байгуулагдаж феодализм бүрэлдэн тогтсон нь" УБ., 2002он
5. Лүндэндорж Н. Эрх зүйн сэтгэлгээний чиг хандлага УБ., 2003 он
6. Лүндэндорж Н. Төрийн онол УБ., 2005 он
7. Монголын төр, эрх зүйн түүх УБ., 2010 он
8. Монголын философийн түүх УБ., 2000 он
9. Санждорж.М "Монгол төрийн түүхээс" УБ.,1998он
10. Баярхүү.Г, Монголын нэгдсэн төрийн болон дараа үеийн хууль цааз, заншлын хэм хэмжээг харьцуулан судалсан нь /XIII-XVIII зуун/ УБ., 1997 он
11. Жамбал.А, Улс төрийн сургаалийн түүх УБ., 2001он
12. Жүгдэр. Ч Монголд феодализм тогтох үеийн нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээ /Эртнээс XIV зуун хүртэл/ УБ., 1987 он
13. Жүгдэр. Ч, XV-XVIII зууны Монголын нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээний хөгжлийн тойм УБ., 1984 он
14. Юндэндорж А. Эртнийорно, дорнын мэргэдийн улс төрийн сэтгэлгээний онол, сургаал, тэргүүн дэвтэр, УБ., 2001 он
15. Юндэндорж.А, Атар.Ю, Орно, дорнын мэргэдийн нийгэм-улс төрийн онол, сургаал, дэд, гутгаар дэвтэр, УБ., 2003 он
16. Чагдаа Х. "Монголчуудын философи сэтгэлгээний үүсгэл, түүхэн уламжлал УБ., 2006 он
17. "Монгол төрийн үүсэл, ёс ёслол, бэлгэдэл, хүндэтгэл, уламжлал УБ., 2011 он
18. Төр, сүм хийдийн харилцаа: Орчин үе УБ., 1998 он.

<sup>4</sup> Төр, сүм хийдийн харилцаа: Орчин үе УБ.,1998 он, 100 дахь тал